

«ШИНЭ ТОЛЬ ХЭМЭЭХ БИЧИГ» СОНИНЫ ЗАРИМ НИЙТЛЭЛИЙН  
ЗОХИОГЧИЙГ ТОДРУУЛАХ АСУУДАЛД

Н.Ариунзаяа\*

\* «Соёл эрдэм» дээд сургуулийн багш, сэтгүүл зүйн магистр, докторант

**Түлхүүр үг:** “Шинэ толь хэмээх бичиг”, Ж.Цэвээн, ууган сонин, “Уулын өвгөн”, хэл найруулга, нийтлэл, нууц нэр.

**М**онголын ууган тогтмол хэвлэлүүдэд зохиогчийн нэрийг бараг тавьдаггүй, тавьсан ч нууц нэр хэрэглэдэг байсан нь тухайн цаг үеийн зөрчилт байдалтай холбоотой юм. Энэ нь Ж.Цэвээний нийтлэлийн бүтээлийг бүртгэн судлахад багагүй бэрхшээл учруулж иржээ. Тухайн цагтаа нөхдийн дунд өргөн дэлгэр мэдлэг, хэлний боловсрол, үзсэн дуулсан, явсан суусан бүхнээрээ ялгарч байсан энэ хүн «Шинэ толь хэмээх бичиг», «Нийслэл хүрээний сонин бичиг» хоёрын зонхилох материал, тухайлбал эрдэм шинжилгээний өгүүлэл, томоохон нийтлэл, орчуулгын зохиолыг голлон бичдэг байсан нь эргэлзээгүй юм. Эдгээрийн дотроос «Монголын мухар огдой», «Бэгз», «Аюурвашида», «Уулын өвгөн», «Нофу», «Хардорж», «Монгол түшмэл» зэрэг нэрээр гарсан бүх нийтлэл түүний бүтээл ажээ. Түүнчлэн «Шинэ толь хэмээх бичиг» сонинд «Монголын есөн хуруут» гэсэн зохиогчтойгоор нийтлэгдсэн материалуудын өгүүлэх арга маяг,

хэл найруулга Ж.Цэвээний нийтлэлтэй нэн төстэй байгааг цаашид тодруулах шаардлагатай юм.

Бидэнд лавтай мэдэгдэж байгаагаар «Шинэ толь хэмээх бичиг»-т нийтлэгдсэн «Ертөнцүүдийн анх тогтсон учир», «Хар тамхины учир», «Жибан улсын учир», «Хөлөнбуйр мужийн загас агнасны учир» зэрэг гэгээрүүлэх чиглэлтэй олон өгүүлэл, тайлбар, Англи, Герман, Итали, Франц, Орос зэрэг орны тухай танин мэдэхүйн шинжтэй материал, «Монгол улсыг шүүмжилбээс», «Монгол газрыг колони болгосугай гэсэн нь», «Монгол улсын дундах байдлыг шүүмжилбээс», «Орос улсын энэ жилийн январь сарын аравны өдөр Монголын элчин сайд нөхөр сэлт Их Орос улсын Хаан эзэнд бараалхсан нь», «Чухал өгүүлэл», «Монголын сургуулийн учир» гэх зэрэг улс төр, соёл боловсролын сэдэвтэй өгүүллүүд, Грамштерны «Хөх Монголын хөх туг» роман, Лев Толстойн «Бурхан багш» зохиол, Иван Крыловын ёгт үлгэрүүдийн орчуулга, «Богд хан уулын магтаал» болон «Нийслэл хүрээний сонин бичиг»-т нийтлэгдсэн «Шүүмжлэл», «Республик хэмээх Бүгд Найрамдах захиргаа» зэрэг нийтлэлүүд Ж.Цэвээнийх мөн ажээ.

«Шинэ толь хэмээх бичиг»-т Д.Бодоо, Д.Бадрахбаатар, Н.Жанцансамбуу нар орон тоогоор ажиллаж, Б.Дорж, Цогтнэрэн нар идэвхтний журмаар мэдээ материал бичдэг байжээ. Тус сонины 1914 оны найм дахь дугаарт нийтлэгдсэн «Бичгийн өртөө байгуулах нь» гэдэг өгүүлэл «Говийн их сургамжит хичээнгүй» хэмээн алдаршсан Б.Доржийн бүтээл мөн бололтой. Учир нь уг өгүүллийн агуулга Б.Доржоос Богд хаант Монгол улсын доод, дээд хуралд оруулан хэлэлцүүлж байсан «Бичгийн өртөө байгуулах» төсөлтэй таарч байгаа юм. Сонины 1914 оны тав, зургаадугаарт өөр өөр асуудлыг хөндсөн атлаа «Өгүүлэл» гэсэн адилхан гарчигтай нийтлэгдсэн хоёр бичлэгт зохиогч Цогтнэрэн нэрээ тавьсан байна. Д.Бодоо зарим хурц шүүмжлэлт нийтлэлдээ «Болд илд» гэсэн нууц нэр тавьдаг, Д.Бадрахбаатар бичсэн зүйлдээ ил, нууц аль ч нэр хэрэглэдэггүй байсан боловч, энэ хоёр сэтгүүлч гол төлөв аж ахуй, улс төрийн сэдэвтэй материалыг хариуцан бичдэг байлаа. Ингэхээр «Шинэ толь хэмээх бичиг» сонины хорин дугаарт нийтлэгдсэн нийт 200 гаруй материалын дотор Ж.Цэвээний бичсэн зүйл арвин байх бололцоотой юм.

Аль ч үеийн сонин сэтгүүлийн нийтлэлийн бодлого, агуулга чанар, бичлэгийн ур чадвар түүнийг эрхэлж, ажиллаж байгаа хүмүүсийн оюуны чадавхиас ямар нэг хэмжээгээр шалтгаалж байдаг нь мэдээжийн хэрэг. «Шинэ толь хэмээх бичиг» сонины үг, өгүүлбэр бүхнээс хүнд хэрэгтэй санаа, эрдэм ухаан сацарч байдаг нь эрхлэгч Ж.Цэвээний соён гэгээрүүлэгч чанар, үзэл санаатай салшгүй холбоотой юм. Түүний бичсэн

зүйлүүд «Шинэ толь хэмээх бичиг»-ийн ноён нуруу болж, гэгээрүүлэгч шинжийг өргөж байжээ.

**Ж.** Цэвээн 1915 оны Орос, Хятад, Монгол гурван улсын хэлэлцээрт хэлмэрчээр оролцож ирснийхээ дараа «Шинэ толь хэмээх бичиг» сонины үргэлжлэл болгож «Нийслэл хүрээний сонин бичиг»-ийг гаргасан бөгөөд энэ сонинд ч мөн олон өгүүлэл материал бичсэн бололтой байна. Хүндрэлтэй нь нийтдээ нэг зуу гаруй дугаар гаргасан энэ сонинд зохиогчийн нэрийг бараг тавихаа байсан явдал юм. Түүнийг гурван улсын хэлэлцээрт явуулсан нь засаг төр, ихэс дээдсийг шүүмжилсэн элдэв юм бичдэг сониныг нь тасалдуулах шалтаг байсныг Ж.Цэвээн сайн мэдэж байсан бөгөөд хурц шүүмжлэлт нийтлэл бичигч өөрийгөө болой нөхдөө хамгаалахын тулд нэргүй нийтлэл гаргах аргад шилжсэн байхыг үгүйсгэх аргагүй. «Нийслэл хүрээний сонин бичиг»-т «хүргэн ирүүлсэн захидал», «сонинд ирсэн бичиг» гэх мэт бичлэг хэд хэд тааралдаж байгаа нь сонины ажилтнуудын бичсэн зүйл байсан байж ч болох юм. Нийтдээ дөрвөн жил таван сар орчим хугацаанд тасралтгүй гарсан энэ сонинд Ж.Цэвээний «Хардорж», Д.Бодоогийн «Болд-илд» гэдэг нууц нэр тус бүр нэг удаа, хэн нэгэн бичээчийн «Алтанбишгүүр» гэдэг нэр нэг удаа, түүнчлэн баруун аймгийн Ишгалсан, Өнцөг хошууны өвгөн Ха гэсэн нэрс ганц ганц удаа тааралдаж байгаагаас өөр зохиогчийн нэр үзэгдэхгүй байгаа нь нэр нийтлэхээс ихээхэн зайлсхийдэг болсныг харуулж байгаа юм. Гэвч зонхилон бичдэг сэдэв, найруулгын ур маяг, нэрээ тавьсан

нийтлэлүүдийнх нь үгсийн сантай харьцуулан үзэх зэргээр Ж.Цэвээний зарим бүтээлийг тогтоон тодорхойлох бололцоо бий. Юуны өмнө дээрх аргаар шинжиж «Республик хэмээх Бүгд Найрамдах захиргаа» (1917, №63), «Байлдааны Оросын төрийн байдал» (1917, №66), «Орос улсын большевик хэмээх Их санаат намын учир» (1918, №72), «Монгол хэлбичгийг сайжруулах тухай» (1918, №116), «Өнгөрсөн жилийг үднэ, ирэх жилийг угтана» (1917, №46) зэрэг өгүүлэл болон тус сонинд нийтлэгдсэн «Шүүмжлэл», «Эсэргүүцэл» гэх мэт цуврал өгүүлэл, шүүмжлэлийн заримыг Ж.Цэвээний бүтээл гэж үзэх санал дэвшүүлсэн доктор, профессор Л.Норовсүрэнгийн саналтай нэгдэхийн зэрэгцээ, «Шинэ-толь хэмээх бичиг» сонинд нийтлэгдсэн Япон, Герман, Итали, Голланд, Болгар, Черногор, Франц, Англи зэрэг орны тухай материал, түүнчлэн «Хүний шүтэх шашны учир», «Хүний насны учир» гэх зэрэг бичлэгийг ч Ж.Цэвээнийх гэж үзмээр байдаг. Учир нь дэлхийн улс орнуудын лавлах мэт ном зохиол, гарын авлага монгол хэлээр гараагүй байсан тэр үед орос, франц хэлбичгийн боловсролтой Цэвээний гэр бүлийнхнээс өөр ийм сэдвээр бичих хүн тус сонинд хараахан байгаагүй байна.

1921 оны үндэсний ардчилсан хувьсгал хийгээд түүний дараах жилүүдэд Ж.Цэвээн сэтгүүлчийн ажлаас хөндийрөөгүй бөгөөд «Монголын үнэн», «Ардын эрх», «Үнэн», «Хувьсгалт залуучуудын эвлэл» зэрэг сонин сэтгүүлд нийтлэл бичиж байв. Ялангуяа Монголын хувьсгалчдаас «Монголын үнэн» сониныг Эрхүү хотод нууцаар гаргаж байх үед Ж.Цэвээн Коминтерний Алс Дорнодын

хороонд ажиллаж байсан бөгөөд тус сочины ажилд тусалж хувьсгалын зорилт, намын тактикийн бодлогыг тодорхойлсон нийтлэлүүдийг уншиж зөвлөхийн зэрэгцээ «Эрмэлзэх арван зүйл», «Намын хүний дагаж явах тангаргийн бичиг» зэрэг удирдамжийн чанартай баримт бичгийн эхийг боловсруулалцаж, улмаар нууц сонин, ухуулах бичгүүдэд нийтлэх ажилд оролцсон байна. Түүнийг үндэсний ардчилсан хувьсгалын томоохон үзэл сурталчийн нэг байсан гэж үзэж болно.

Ж.Цэвээн хувьсгалын дараах жилүүдэд «Монголын онгон сүлд, дархан тайлгатай газруудыг онц болгоё» («Ардын эрх», 1927, №50), «Дэлхийн баялгийг бадруулах нь» («Үнэн», 1926, №8), «Ард олныг эрдэм соёлд гэгээрүүлэх тухай» («Үнэн», 1926, №39), «Монголын хувьсгалт залуучуудын эвлэл ба бүдийн шашин» («Хувьсгалт залуучуудын эвлэл» сэтгүүл, 1927, №9) гэх зэрэг олон арван өгүүлэл, нийтлэл бичсэн юм. Тэдгээр нийтлэлийн зарим нь хожим «Шинжлэх ухаан, амьдрал», «Түүхийн судлал», «Монгол судлалын мэдээлэл», «Ил товчоо» зэрэг сонин, сэтгүүлд нийтлэгдсэн байна.

**Ж.** Цэвээн «Монголын хувьсгалт залуучуудын эвлэл ба бүдийн шашин» гэдэг өгүүлэлдээ төрөөс шашны талаар баримтлах бодлого, тэр дундаа бурханы шашинд хүндэтгэлтэй хандахын учрыг тайлбарласан нь ихээхэн ач холбогдолтой зүйл байжээ. Тэрбээр өгүүлэлдээ ардын засаг төрөөс шашин шүтэхийг албадан шахахгүй бөгөөд түүнийг хүний дур сүсгийн хэрэг болгон чөлөөтэй тавьж ардын хувийн эрх чөлөөг хүндэтгэх

учиртайг анхааруулжээ. Тэр дундаас уламжлалт бурханы шашинд онцгой хүндэтгэлтэй хандах гурван их учир байгааг заажээ. Түүнийг сийрүүлбэл: «Нэгэн дор болбоос, нам ба нам үгүй ард олноор шашинд сүслэж заншсан суртал ба олон түмэн лам хуврагуудын сэтгэл санааг тэвчихгүй хэмээсэн нь буй заа. Хоёр дор болбоос, бурхан шигмунийн шашин ном нь хамаг амьтныг хэм тэгш нигүүлсэн үзэж зовлонгоос гэтэлгэн, жаргалант байдалд оруулсугай хэмээн цаглашгүй энэрэхүй сэтгэлээр эзлэгдсэнээс гадна хамгийн нарийн учир шалтгааныг үндсээр нь шинжлэн үнэн зөвийг олж, үйлийн үр ба хоосон чанарыг номлосон нь маш гүн болоод элдэвчлэн шинжлэвч шалгадаг ухаанд үл харшлан тавтайяа нийлэлцэх тул үнэхээр бишрэн хүндэтгэж, дотночлон үзсэн нь буй заа. Гурав дор болбоос, Монгол газар бурхан шашин дэлгэрэхийн хамт бүрхэг харанхуй байсан манай монголчуудын оюун билэг нь сая нээгдэж, үсэг бичиг сурах ба орон хүрээ барьж суурьшин суух ба судар сургууль хийх, эмчлэх сувилах ба догшин хэрцгий зан авираа гээж, номхон дөлгөөн болоод хар цагаан үйл, буян нүглийн ялгал сэлтийг ойлгон мэдэж, аливаа соёл боловсролын замыг олсны тул бурхан шашны ач тусыг таньсан нь буй заа» гэсэн байна.

Тэрбээр «Монгол улсын эрдэм шинжилгээний ажлын ач холбогдол»

гэдэг өгүүлэлд Монгол орон соёлын талаар Европын орнуудаас олон зуун жилээр хоцорсонд санаа зовинож бичихдээ «Шинжлэх ухаан цэцэглэн хөгжиж байгаа газарт л амьдралын ая тохь бий болж, ард түмэн соёлын бүх үр шимийг хүртдэг. Тэнд үхэр тэргээр явж ачаа тээхийн оронд автомашин, төмөр замаар хурдалж, бүгд агаарын онгоцоор нисцгээж, гол, тэнгист уурын онгоцоор зорчицгоодог. Холын замыг туулахын тулд их цаг үрэх хэрэг гардаггүй, тэнд газрыг товчилж мориор арван хоног явахын оронд нэг хоног, тэр ч атугай хэдхэн цаг зорчдог» гэхчилэн таниулаад, Монгол орон явал шинжлэх ухаан, соёлыг эрчимтэй хөгжүүлж болох талаар оновчтой санал дэвшүүлсэн байдаг. Эдгээр бичлэг нь Ж.Цэвээний соён гэгээрүүлэх үзлийн тод жишээ мөн.

«

*Монгол бичгийн найруулгын сондгойруулахгүй байх зарчмыг баримталсан байдлаараа Ж.Цэвээний нийтлэл, зохиол бусдаас ялгарч байна. өгүүлбэрийн доторх үг болон гишүүн өгүүлбэрийн үгийг тэнцүү тоотой найруулдаг нь түүний нийтлэлийн бас нэг онцлог ажээ.*

»

гээр бичлэг нь Ж.Цэвээний соён гэгээрүүлэх үзлийн тод жишээ мөн.

«Шинэ толь хэмээх бичиг» сонины сүүлчийн дараалсан дөрвөн дугаарт дамжин нийтлэгдсэн «Их ноён Хуучин, мэргэн багш Ёст, орос Магад, хятад Ёслол нар цайлж, ажиггүйн оронд зөвлөн тэмцсэн дөрвөн замын уулзвар нь» гэдэг нийтлэлийг бид Ж.Цэвээний бүтээл хэмээн үзэж байна. Ингэж үзэх хэд хэдэн үндэслэл байгаа нь нэгд: уг нийтлэлийн үгийн сан, найруулгын хэв маягийг Ж.Цэвээний бусад хэд хэдэн нийтлэл, тухайлбал «Чухал өгүүлэл», «Шүүмжлэл», «Монгол улсын дундах байдлыг шүүмжилбээс» зэрэг нийтлэ-

лийнхтэй харьцуулан үзэхэд адил зүйл олон байгаа явдал мөн. Жишээ нь «атгаа», «голын багана», «осол залхаах», «сургуулийн засаг», «тотгорлох», «чанадыг татах», «манагаар», «нэгээхэн бээр», «өдөр түлхэх» гэх мэт тэр үеийн бусад зохиогчдын бүтээлд тэр бүр тааралдахгүй байгаа үгсийг түгээмэл хэрэглэсэн байна. Хоёрт: монгол бичгийн найруулгын сондгойруулахгүй байх зарчмыг баримталсан байдлаараа Ж.Цэвээний нийтлэл, зохиол бусдаас ялгарч байна. «Тотгор саад болсон зүйлүүдийг зайлуулж, тус болох зүйлүүдийг бүртгэн гүйцэтгэнэ», «зан суртал, санал үзэл», «ард албатыг адил үзэж, асрах бадрахын үндсийг уудалж», «ирээдүй цагийн идэрхэг хүчин, яруу алдар, одоо цагийн шударга журам, олны тус», «тунгалаг нэр, хүнд хишиг, хэтэрхий цалин», «авир зан, ааш явдал», «үнэнч ариун, хичээнгүй шударга», «номын ёс, шашны суртал», «оюун билиг нь нээгдэж, үсэг бичиг сурах, орон хүрээ барьж, суурьшин суух» гэх зэргээр өгүүлбэрийн доторх үг болон гишүүн өгүүлбэрийн үгийг тэнцүү тоотой найруулдаг нь түүний нийтлэлийн бас нэг онцлог ажээ.

Гуравт: адил дуудлагатай ба эсрэг утгатай үгээр толгой, сүүл холбох, тэсрэх шуугих, хамжих шүргэх гийгүүлэгчийг хоршуулан хэрэглэх, ингэснээрээ нийтлэлийн яруу сонсголонт чанарыг нэмэгдүүлэх найруулгын аргыг өргөн хэрэглэдэг нь түүний нийтлэлд түгээмэл юм. Үүнд «алсын санал бодол, улсын хүнд хишиг», «омгорхон хавчих, огоорон тэвчих», «олох ашиглах, таслах хуваах», «ардын зүдгүүрийг тасалж, улсын нэрийг хүлээх» гэх мэт олон жишээг дурдаж болно.

«Дөрвөн замын уулзвар»-ыг Ж.Цэвээний бүтээл гэж үзэх өөр нэг үндэс нь уг нийтлэлд шингээсэн улс төрийн үзэл бодол хийгээд зохиомжийн арга барил юм. Юуны өмнө уг нийтлэлд ХХ зууны эхэн үеийн Орос, Хятад, Монгол гурван улсын улс төрийн бодлогын эгзэгтэй, нарийн асуудлыг гүнзгий мэдлэгтэйгээр хөндсөн байдаг. Тэгэхдээ нийтлэл ба уран зохиолын зааг дээр, бичлэгийн олон зүйлийн хослол байдалтайгаар туурвисан, өөрөөр хэлбэл сонины бичлэгт цоо шинэ арга барил, өнгө аясыг оруулж ирсэн байна. «Дөрвөн замын уулзвар» нэг талаас буух мөр, буцах эзэнгүй бөгөөд баатруудад төлөөллийн нэр өгсөн байдлаараа уран зохиол, тухайлбал «үг» зохиолын шинжтэй юм. Төрөл, зүйлийн хувьд харилцан ярианы хэлбэртэй учир ярилцлагатай, ярианы орчин нөхцлийг тодорхой зааж, өөрөөр хэлбэл тайзны байдлыг төлөвлөж өгснөөрөө яриан жүжгийн зохиолтой тус тус төстэй байдаг. Баатруудын яриа нь учирлаж тайлбарласан, егөөдөж түншсэн, дайрч давшилсан, хүлцэж хүлээсэн, шоглож даажигнасан олон янзын өнгө аястай байгаа нь зохиогч утга зохиолын арвин мэдлэг, туршлагатай хүн болохыг харуулж байна. Тухайн үедээ гурван улсын хар, шар ихэс дээдсийн дургүйцлийг төрүүлж, сониныг тасалдуулан хаах нэг шалтаг болсон энэ нийтлэлийг хэд хэдэн дугаар дамжуулан бүтэн нүүрээр нийтлэх зохиогч тэр үед улс төрийн том бодлоготон, нэрд гарсан эрдэмтэн, их бичгийн хүн Ж.Цэвээнээс өөр байх бололцоогүй юм. Ийм учир шалтгаануудыг үндэслэн уран зохиол, нийтлэлийн аргыг хослуулан бичсэн улс төрийн энэ нийтлэлийн зохиогч нь «Шинэ толь

хэмээх бичиг» сонины эрхлэгч Ж.Цэвээний бүтээл гэж үзэж байна.

«Шинэ толь хэмээх бичиг» сонины дараачаар гарсан «Нийслэл хүрээний сонин бичиг» улс төрийн чиглэл, зорилгоороо адил боловч, хэлбэр хэмжээ, гаргасан дугаарын тоо, нийтэлсэн материалын сан хөмрөгөөрөө анхны сонинноос хэдэн арав дахин их юм. Тус сонины 103-н дугаарт гарсан хэдэн зуун материалын дотор Ж.Цэвээний бичсэн зүйл арвин байгаа бөгөөд тэдгээрийг зонхилох сэдэв, үгсийн сан, найруулгын ур маягаар нь зохиогчийн нийтэд ил болсон, өөрөөр хэлбэл нэрээ тавьж гаргасан нийтлэлүүдтэй нь харьцуулан судлах замаар тодруулах шаардлагатай байгаа юм.

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баасансүрэн Т. 2009. ХХ зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл. (Тэргүүн дэвтэр). УБ.

2. Дэлэг Г. 1965. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тойм. УБ.

3. Норовсүрэн Л. 2000. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. (Тэргүүн боть). УБ.

4. Норовсүрэн Л. 2005. Монголын нийтлэл. (Дэд дэвтэр). УБ.

5. Норовсүрэн Л. 1999. Монголын сэтгүүл зүйн өмнөх үзэгдлүүд. УБ.

6. Цэвээн Ж. 1998. Түүвэр зохиолууд. (Нэгдүгээр дэвтэр). УБ.

7. Цэвээн Ж. 2010. Нийтлэл, тэмдэглэл, захидал. УБ.

#### Резюме

Данная статья посвящена анонимным публикациям первых национальных газет Монголии — «Шинэ толь хэмээх бичиг» («Газета, именуемая Новое зеркало») и «Нийслэл хүрээний сонин бичиг» («Столичная газета»). Автор, на основании семантического и стилистического анализа, предпринял попытку установить авторство некоторых материалов, опубликованных в выше-названных газетах, под псевдонимом или без указания имени автора. Автор пришёл к выводу, что более 10 анонимных публикаций вышли из-под пера первопроходца монгольской журналистики Ж.Цэвээна.